

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ, УДИРДЛАГА

АЙМГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

КОМИССЫН ДАРГА



Аймгийн засаг дарга
О.БАТ-ЭРДЭНЭ

КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА



Статистикийн
хэлтсийн дарга
Б.ЭНХУЯА

КОМИССЫН ГИШҮҮД



ИТХ-ын нарийн
бичгийн дарга
Ц.МӨНГӨНЦООЖ




Аймгийн тамгын
газрын дарга
Ц.ЭРДЭНЭСҮРЭН



Санхүү төрийн
сангийн хэлтсийн
дарга **А.ГАНБАТ**



Хөрөнөө оруулалт
хөгжлийн бодлогын
хэлтсийн дарга
Н.ЭРДЭНЭ-ОЧИР



Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга
А.НАРАНТУЯА



Цэргийн штабын
дарга **Ш.ГАНСҮХ**



Авто тээврийн
төвийн дарга
Ц.БЯМБАЦОГТ



Боловсрол, соёл,
урлагийн газрын
дарга



Газрын харилцаа,
барилга, хот
байгуулалтын газрын
дарга **Э.ЧАГНААДОРЖ**



Онцгой байдлын
газрын дарга
Хурандаа
М.АЛЪЯАБААТАР



Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын
дарга
Г.ХИШИГДАВАА



Цагдаагийн газрын
дарга Хурандаа
О.АМАРСАНАА



Эрүүл мэндийн
газрын дарга
Г.БАТ-ОРШИХ



Улсын бүртгэлийн
хэлтсийн дарга
Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ



Шүүхийн шийдвэр
гүйцэтгэх албаны
дарга Хошууч
Б.ЕСӨН-ЭРДЭНЭ



Байгаль орчин аялал
жуулчлалын газрын
дарга **Н.ГАНТУЛГА**



Сайнцагаан сумын
засаг дарга
Р.МӨНХТОГОХ



Статистикийн
хэлтсийн ахлах
мэргэжилтэн
Т.БЯМБАСҮРЭН



ЗДТГ-ын хэвлэл
мэдээллийн ажилтан
Б.УНДАРМАА

ТҮР ТОВЧООНЫ ГИШҮҮД



*Тооллогын товчооны
дарга*
Б.ЭНХТУЯА



*Тооллогын товчооны
орлогч дарга*
Б.БЯМБАСҮРЭН




*Тооллогын товчооны
гишүүн*
Г.АРИУНЖАРГАЛ



*Тооллогын товчооны
гишүүн*
Г.САЙХАНТУЯА



*Тооллогын товчооны
гишүүн*
Э.ГАНТУЛГА



*Тооллогын товчооны
гишүүн*
Н.ТАМЖИДМАА




*Тооллогын товчооны
гишүүн*
Б.БАТСҮРЭН



*Тооллогын товчооны
гишүүн*
Д.ЧОГСОМЖАВ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ




ХҮН АМЫН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Хүн амын тоо гэдгийг энгийнээр хэлвэл, тодорхой хугацаанд тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа нийт хүмүүсийн тоо гэж ойлгож болох боловч НҮБ-ын аргачлалаар бэлэн болон суурин хүн амын тоо гэсэн хоёр өөр ойлголтоор тодорхойлдог. Нийт хүн ам буюу бэлэн хүн ам гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат хүн амыг хамруулна. Харин суурин хүн амын тоо гэдэгт Монгол Улсын засаг захиргааны нэгжид 6 буюу түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг ойлгоно.

Хүн амын тооны өөрчлөлт нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, ард түмний аж байдлын түвшин, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг олон хүчин зүйлтэй уялдан хүн амын үндсэн үзүүлэлт болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлогддог.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Дундговь аймгийн хүн ам 47104 боллоо. Дундговь аймгийн хүн ам 1963 оноос 2 дахин, 2010 оноос хойш жилд дунджаар 2.4 хувиар өсжээ. Дундговь аймгийн суурин хүн ам 46698, гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа хүн амын тоо 429 болсон. Харин Дундговь аймагт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат хүн 23 байна.

ЗУРАГ 2.1. ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙТ ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр Дундговь аймгийн хүн амын тоо 47.1 мянга болсон нь 2010-2020 оны хооронд буюу 10 жилийн хугацаанд 8.2 мянган хүнээр өсжээ. Дундговь аймгийн хүн амын 50.2 хувийг эрэгтэйчүүд, 49.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 101.0 болж, өмнөх тооллогын түвшнээс 2.3 пунктээр буурав. /Хүснэгт 2.1/

ХҮСНЭГТ 2.1. ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙТ ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1963	28 785	14 100	14 685	96.0
1969	30 706	15 220	15 486	98.3
1979	38 937	19 482	19 455	100.1
1989	49 320	24 604	24 716	99.5
2000	51 517	25 719	25 798	99.7
2010	38 820	19 727	19 093	103.3
2020	47 104	23 669	23 435	101.0

Хүснэгтээс харахад 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоо 2010 оны тооллогоор хамгийн өндөр түвшинд байсан бөгөөд 1963 оны тоологоос хойш тасралтгүй өсөж байгаад 2020 оны тооллогоор ялимгүй буурсан үзүүлэлттэй байна. Үүнд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, гадаад, дотоод шилжих хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тодруулбал, гадаад руу явж байгаа ажиллах хүчний шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байдаг. Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн бас нэг гол тулгуур болох уул уурхайн хөгжилтэй уялдан ажиллах хүчний шилжилт явагдан, улмаар орд газруудыг түшиглэн хүн амын төвлөрөл үүсч байгаа ба тэнд ажиллагсдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа нь хүйсийн харьцаа буурахад нөлөөлсөн байж болох талтай.

ХҮН АМЫН ӨСӨЛТ

Хүн амын тооны өөрчлөлтийг цэвэр өсөлт (төрөлт, нас баралтын зөрүү) болон механик өсөлт (шилжих хөдөлгөөн)-өөр тодорхойлдог. Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн бодлого, хөгжлөөс ихээхэн хамаардаг.


Дундговь аймгийн хүн ам 1989-2000 онд 2.2 мянган хүнээр буюу жилд дунджаар 0.4 хувиар өссөн бол 2000-2010 оны хооронд 12.7 мянган хүнээр буюу жилд дунджаар 2.2 хувиар буурч байжээ. Харин 2010-2020 оны хооронд 8.3 мянган хүнээр буюу жилд дунджаар 2.4 хувиар өссөн байна.

Сумдын хүн амын тооллого хоорондын жилийн дундаж өсөлтийн дүр төрх 2000-2010 онд өмнөх 10 жилийнхээс эрс ялгаатай, тухайлбал 1989-2000 онд 2 сумаас бусад бүх сумдын хүн ам бараг жигд өсч байсан бол 2000-2010 онд бүх сумын хүн ам өмнөхөөс эрс буурсан байна. Энэ нь төрөлтийн түвшин буурч, шилжих хөдөлгөөн нийслэл, суурин газар луу чиглэсэнтэй холбоотой. Харин сүүлийн 10 жилд Өндөршил сумаас бусад бүх сумдын хүн ам жилд дунджаар 1.4-5.6 хувиар өссөний дотор Цагаандэлгэр, Хулд, Дэрэн, Дэлгэрцогт сумын хүн ам 4.0-өөс дээш хувиар өссөн нь сүүлийн жилүүдэд иргэдийн нутаг орондоо амьдрах таатай боломжийг бүрдүүлэхийг зорьж ажилласан төр засгийн бодлого шийдвэрийн үр дүн, мөн цаг

агаар сайхан байж, малчид нутаг орондоо өвөлжих боломжтой байсан зэрэг эерэг нөлөөллүүдийн үр дүн байлаа.

ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР, ХУВИАР

*Гадаадад 6, түүнээс дээш хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо орсон.



Хүснэгт 2.2. Хүн амын ердийн хөдөлгөөний үзүүлэлт, 2010-2020 он

Он	Ерөнхий коэффициент		
	Төрөлт	Нас баралт	Цэвэр өсөлт
2010	20.8	6.7	14.1
2011	20.0	6.6	13.4
2012	21.2	6.5	14.7
2013	23.2	6.4	16.8
2014	23.3	6.1	17.2
2015	24.6	7.1	17.5
2016	24.5	6.9	17.5
2017	22.3	5.5	16.9
2018	25.6	6.7	18.9
2019	25.5	6.8	18.7

Манай аймгийн хувьд 2010-2020 онд хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас 0.2 пунктээр өндөр байна. 2020 оны тооллогын дүнгээр Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Баян-Өлгий, Говьсүмбэр аймгууд болон Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас 0.2-1.7 пунктээр өндөр байгаа юм. Хүснэгт 2.3. хүн амын өсөлт, СУМДААР, хувиар, 1989-2000, 2000-2010, 2020-2020 он

Сумд	2000/19 89 (%)	2010/200 0 (%)	2010/202 0 (%)	Жилийн дундаж өсөлт (%)		
				1989- 2000	2000-2010	2010-2020

Дэлгэрцогт	114.1	47.6	141.7	1.28	-5.2	4.6
Дэрэн	132.2	59.0	146.0	2.93	-4.1	5.1
Говь-Угтаал	105.6	70.8	118.1	0.51	-2.9	2.0
Цагаандэлгэр	106.0	40.8	156.5	0.55	-5.9	5.6
Баянжаргалан	92.2	82.8	115.1	-0.71	-1.7	1.7
Өндөршил	109.9	93.2	98.7	0.90	-0.7	-0.1
Гурвансайхан	116.6	66.9	127.9	1.51	-3.3	3.1
Өлзийт	113.8	59.4	136.3	1.25	-4.1	4.0
Хулд	112.6	66.6	147.8	1.15	-3.3	5.3
Луус	110.5	70.8	138.0	0.95	-2.9	4.2
Дэлгэрхангай	120.8	70.8	122.3	1.89	-2.9	2.5
Сайхан-Овоо	127.9	68.0	112.8	2.54	-3.2	1.4
Эрдэнэдалай	118.0	72.4	115.2	1.64	-2.8	1.7
Сайнцагаан	82.2	94.1	116.8	-1.62	-0.6	1.9
Адаацаг	137.8	71.8	120.6	3.44	-2.9	2.3


ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын насны бүтэц нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан аймаг, орон нутгийнхаа нийгэм эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах шаардлагатай байдаг.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг. Нөгөө талаар хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний чиг хандлага ч насны бүтцээс хамааралтай байдаг. Тухайлбал: Хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болоход /нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нэмэгдэх үйл явц/ цаашид хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүний онцлогийг харгалзан ямар төрлийн ажлын байр илүү хэрэгцээтэй болохыг тодруулах шаардлага гардаг.

Дундговь аймгийн хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа боловч 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 0-14 насны хүн амын эзлэх хувь 1.3 пунктээр буурч, 15-64 насныхны эзлэх хувь 1.3 пунктээр өссөн нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна.

Зураг 2.3. Хүн АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ХУВИАР, 2000, 2010, 2020 он



Нийт хүн амын тоонд насны бүлэг тус бүрийн хүн амын эзлэх хувийн жин 2020 онд 2010 оныхоос зарим насанд өөрчлөлт гарсан харагдаж байна. Тухайлбал: 0-9 насны хүн амын эзлэх хувийн жин 2010 онд 16.9 байсан бол 2020 онд 21.3 болж, 4.4 пунктээр өсчээ. Энэ нь сүүлийн 10 жилд төрөлтийн түвшин өссөнийг харуулж байна.

Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалт харьцангуй ялгаатай (2019 оны байдлаар дундаж наслалт эрэгтэй- 71.07, эмэгтэй 79.04) байдагтай холбоотой.

ХҮСНЭГТ.2.4. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН


Насны бүлэг	2010		2020		Хүйсийн харьцаа ¹	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	103.2	101.1
0-4	11.3	10.9	12.0	11.4	107.6	106.0
5-9	9.6	9.5	10.0	9.3	103.7	107.0
10-14	10.9	10.7	8.9	8.6	105.0	104.3
15-19	9.0	7.9	8.0	7.6	117.7	106.1
20-24	8.4	7.5	8.6	8.2	115.4	105.4
25-29	8.7	8.8	7.9	7.3	101.3	107.9
30-34	8.4	8.3	7.7	7.4	104.9	103.6
35-39	7.2	7.8	7.3	7.2	95.2	102.2
40-44	6.8	6.5	6.7	6.8	107.6	99.2
45-49	6.1	5.9	5.9	6.1	106.5	95.8
50-54	4.7	5.1	5.2	5.1	94.1	102.0
55-59	2.6	3.1	4.5	4.9	87.2	90.2
60-64	1.8	2.0	2.9	3.8	90.2	76.1
65-69	1.5	1.5	1.6	2.2	101.4	72.9
70+	3.1	4.4	2.6	4.0	73.2	65.7

¹ 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

Хүн амын нас, хүйсийн бүтцийг хүн амын суваргаар харуулах нь хамгийн тохиромжтой арга юм. Энэ нь насны бүлэг бүр дэх эрэгтэй, эмэгтэй хүн амыг хүвийн жин буюу тоогоор харуулдаг хэвтээ байрлалтай тэгш өнцөгт дүрслэл юм. Суурь хэсэгт залуу насны бүлгийн хүн амыг, зүүн гар талд эрэгтэй хүн ам, баруун гарт эмэгтэй хүн амыг байрлуулах зарчимтай. Хүн амын насны бүтцээс хамааран суварга нь өөр өөр хэлбэртэй байж болно.

Хүн амын нас, хүйсийн 2020 оны суваргыг 2010 онтой харьцуулахад суурь хэсгээрээ өргөссөн буюу төрөлтийн түвшин өсч, нас баралтын түвшин буурч байгааг харж болно. Хүн амын ердийн хөдөлгөөний өөрчлөлтөөс шалтгаалан 25-аас дээш насанд суваргын хэлбэр өөрчлөгдөж байна. Тухайлбал: 2010 оны суваргын суурь 0-4 насанд өргөн байгаа нь 2007-2009 онд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой бол 2020 оны суваргын суурь мөн өргөн байгаа нь 2015-2019 онд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой юм. Хорин таваас дээш насанд суваргын хэлбэр аажмаар нарийсч байгаа нь 1990-2000 оны үеийн төрөлтийн бууралттай холбоотой юм.

ЗУРАГ 2.4. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Дундговь аймгийн хүн амын хүйсийн харьцаа 2010 оноос 2.3 пунктээр буурсан байна. Сумдын 2020 оны хүйсийн харьцаа Сайнцагаан, Өндөршил сумдад аймгийн дунджаас 5.3-9.5 пунктээр бага, бусад сумдад аймгийн дунджаас 1.5-19.3 пунктээр дээгүүр байна.

Хүн амын хүйсийн харьцааг 2010 онтой харьцуулахад (Хүснэгт 2.5) Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Луус, Сайхан-Овоо, Сайнцагаан, Адаацаг сумдаас бусад сумын хүн амын хүйсийн харьцаа өмнөх тооллогын үеийнхээс өссөн нь шилжих хөдөлгөөнөөс шалтгаалжээ.

Хүснэгт 2.5. сумдын хүн амын тоо, хүйс, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 он

Сум	2010			2020			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	38 543	19 578	18 965	47 104	23669	23435	103.2	101.0
Дэлгэрцогт	1 166	610	556	1 652	867	785	109.7	110.4
Дэрэн	1 481	759	722	2 162	1 110	1 052	105.1	105.5
Говь-Угтаал	1 312	682	630	1 550	812	738	108.3	110.0
Цагаандэлгэр	674	353	321	1 055	554	501	110.0	110.6
Баянжаргалан	1 135	625	510	1 306	685	621	122.5	110.3
Өндөршил	1 433	740	693	1 415	692	723	106.8	95.7
Гурвансайхан	1 676	854	822	2 144	1 085	1 059	103.9	102.5
Өлзийт	1 757	930	827	2 395	1 308	1 087	112.5	120.3
Хулд	1 623	804	819	2 399	1 233	1 166	98.2	105.7
Луус	1 369	721	648	1 889	981	908	111.3	108.0
Дэлгэрхангай	1 894	945	949	2 316	1 177	1 139	99.6	103.3
Сайхан-Овоо	1 904	996	908	2 148	1 111	1 037	109.7	107.1
Эрдэнэдалай	5 097	2 558	2 539	5 872	2 974	2 898	100.7	102.6
Сайнцагаан	13 664	6 787	6 877	15 957	7 623	8 334	98.7	91.5
Адаацаг	2 358	1 214	1 144	2 844	1 457	1 387	106.1	105.0

Хот, хөдөөд хүн амын хүйсийн харьцаа ялгаатай байна. Хөдөөд хүйсийн харьцаа 106.1 байгаа бол хотод буюу аймгийн төвд 88.6 байна. Хөдөөд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү тоологдсон байна. Энэ нь эмэгтэйчүүд сургуулийн хүүхдээ дагаж Улаанбаатар хот болон аймгийн төвд оршин сууж, эрэгтэйчүүд нь малаа маллаж хөдөө амьдардаг явдал нилээд түгээмэл байгаатай холбоотой. Мөн уул уурхайн салбарт ажиллагчдын тоо нэмэгдсэн, энэ салбарт эрэгтэйчүүд голдуу ажилладаг явдал ч нөлөөлж байна. Үүнээс гадна эмэгтэйчүүд сургуульд суралцах нь эрэгтэйчүүдээс илүүтэй байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 2.6. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН

Хот, хөдөө	2010 он			2020 он		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
БҮГД	19 578	18 965	103.2	23 478	23 220	101.1
Үүнээс: Хот	6 787	6 877	98.7	5 831	6 581	88.6
Хөдөө	12 791	12 088	105.8	17 647	16 639	106.1

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа насыг голч нас гэдэг. Өөрөөр хэлбэл, 2020 онд голч нас 27.4 болсон нь хүн амын тэн хагас нь 27.4-өөс доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна гэсэн үг юм. Сүүлийн 30 жилд голч нас бараг 10 жилээр хойшилсон нь төрөлтийн түвшин буурснаас гадна хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой.

Тооллогын дүнгээр голч нас 27.4 байгаа нь улсын дүнгээс /27.9/, 0.5 пунктээр бага байна.

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт болох хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцаагаар илэрхийлэгддэг. Хүн амын төрөлтийн түвшин өндөр байснаас шалтгаалан 1989 онд хүн ам зүйн ачаалал их байжээ. Тэгвэл 2020 онд хүн ам зүйн ачаалал 54.7 болж 2000 оноос 23.3 пунктээр, 2010 оноос 3.4 пунктээр буурсан бөгөөд улсын дүнгээс 0.6 пунктээр доогуур байна. Энэхүү үзүүлэлт нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хүний хүчин зүйл, тэр дундаа, насны бүтэц хэр нөлөөлж байгааг харуулдаг.

ХҮСНЭГТ 2.7. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ЗАРИМ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2000, 2010, 2020 ОН

Үзүүлэлтүүд	2000	2010	2020
Голч нас /жилээр/	20.3	26.3	27.4
Хүн ам зүйн ачаалал /хувиар/	78.0	58.1	54.7
Үүнээс:			
Хүүхэд	68.8	49.7	46.6
Хөгшид	9.2	8.4	8.1
Хөгшрөлтийн индекс	13.3	16.9	17.5